



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/477

Чингис хот

“Ай Ти Эм” аялал жуулчлалын
Олон Улсын үзэсгэлэнд оролцоход
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн жагсаалт батлах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, эвент арга хэмжээнүүдийг гадаад, дотоодын жуулчид, бизнес эрхлэгчдэд танилцуулан сурталчлах, түр оператор, агентуудтай түншлэлийн гэрээ хэлэлцээр байгуулах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Ай Ти Эм /ITM/ аялал жуулчлалын Олон Улсын үзэсгэлэнд оролцоход 3593400 /гурван сая таван зуун ерэн гурван мянга дөрвөн зуу/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрхи зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх /“Чингис хаан брэнд” дэд хөтөлбөрийн/ зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010787

Аймгийн Засаг даргын 2020 оны
...10... дугаар сарын 14-өдрийн ...1472
дугаар захирамжийн хавсралт

“Ай Ти Эм” аялал жуулчлалын Олон Улсын үзэсгэлэнд
оролцох зардлыг н тооцоо

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Талбайн түрээс	мкв	18	120000	2160000
2	Хулдаасан хэвлэл	мкв	9.2	12000	110400
3	Ханын зураг /хөөсөнцөр дээр хэвлүүлэх/	мкв	5	25000	125000
4	Вертуаль үзүүлэх талбайг тойруулах даавуу	м	30	5000	150000
5	Вертуал түрээс	ш	2*2 өдөр	250000	1000000
6	Прус мод	ш	6	8000	48000
	Нийт				3 593 400